



Зүүн хойд Азийн харилцаа, хамтын ажиллагааны цөм

The Hub of Exchange & Cooperation in Northeast Asia

Зүүн хойд Азийн бүс нутгийн засаг захиргаадын холбоо

The Association of
North East Asia Regional
Governments



Зүүн хойд Азийн бүс нутгийн засаг захиргаадын холбооны Хэрэг эрхлэх газар
The Secretariat of the Association of North East Asia Regional Governments

Зүүн хойд Азийн харилцаа, хамтын ажиллагааны ТӨВ NEAR

The Association of North East Asia Regional Governments



1996 оны 9 сард Зүүн хойд Азийн Солонгос, Хятад, Япон, Орос 4 улсын 29 орон нутгийн захиргаадын дарга нар чуулж, харилцан ашигтай эрх тэгш зарчмаар хоорондын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлж, бүс нутгийн хамтын хөгжил ба дэлхийн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулах зорилгоор тус Холбоог байгуулсан.

Зүүн хойд Азийн бүс нутгийн хамтын хөгжил дэвшил гэгч үзэл санааны дагуу Холбооны үндсэн дүрмийг баталснаас хойш эдийн засаг, худалдаа, байгаль орчин, боловсрол соёлын харилцаа, гамшгаас сэргийлэх, хилийн хамтын ажиллагаа, далай загасны аж ахуй, аялал жуулчлал, ашигт малтмал боловсруулалт зохицуулалт, эрчим хүч, уур амьсгалын өөрчлөлт, хүүхэд эмэгтэйчүүд гэхчлэн төрөл бүрийн салбарт харилцаа, хамтын ажиллагааны төслийг хэрэгжүүлж байна.

Удаагаар нь БНАСАУ, Монгол улсын орон нутгийн захиргааны байгууллагууд гишүүнээр элсснээр одоо тус Холбоо 6 улсын 70 гишүүн байгууллагаас бүрдсэн Зүүн хойд азийг төлөөлөх орон нутгийн харилцаа, хамтын ажиллагааны байгууллага болон өсөн дэвжиж байна.

NEAR гэдэг нь

The Association of North East Asia Regional Governments-ийн товчлол бөгөөд мөн түүнчлэн ойр дотно хэмээх утгатай англи үгийг илэрхийлнэ.

Гишүүн байгууллагууд Members

Зүүн хойд Азийн орон нутгийн байгууллагууд харилцаа, хамтын ажиллагаагаар дамжуулан энх тайван ба хөгжил цэцэглэлт бүхий Зүүн хойд азийн эрин үеийг нээнэ.

6 улсын 70 гишүүн байгууллага



Хятад улс(6)

Хэйлонжан муж, Хэнан муж, Хубэй муж, Хунан муж, Нинся Хуйн ӨЗО, Шаньдун муж




Япон улс(10)

Аомори муж, Ямагата муж, Нигата муж, Тояама муж, Ишикава муж, Фүкүй муж, Киото муж, Хёго муж, Тоттори муж, Шиманэ муж



Солонгос улс(15)

Пусан хот, Дэгү хот, Инчон хот, Гуанжү хот, Дэжон хот, Ульсан хот, Кёнги муж, Канвон муж, Чүнчонбүг муж, Чүнчоннам муж, Жоллабүг муж, Жолланам муж, Кёнсанбүг муж, Кёнсаннам муж, Жэжү муж




БНАСАУ(2)

Хамгёнбүг муж, Насон хот



Монгол улс(22)

Улаанбаатар хот, Архангай аймаг, Баян-Өлгий аймаг, Баянхонгор аймаг, Булган аймаг, Говь-Алтай аймаг, Говьсүмбэр аймаг, Дархан-уул аймаг, Дорнод аймаг, Дорноговь аймаг, Дундговь аймаг, Завхан аймаг, Орхон аймаг, Өвөрхангай аймаг, Өмнөговь аймаг, Сүхбаатар аймаг, Сэлэнгэ аймаг, Төв аймаг, Увс аймаг, Ховд аймаг, Хөвсгөл аймаг, Хэнтий аймаг



ОХУ(15)

Буриадын БНУ, Сахагийн БНУ, Тувагийн БНУ, Алтайн хязгаар, Забайкальск хязгаар, Красноярск хязгаар, Приморийн хязгаар, Хабаровск хязгаар, Амур муж, Иркутск муж, Камчатк хязгаар, Магадан муж, Сахалин муж, Томск муж, Кемеровск муж


Ажиллагч

Хятадын улсын Тяньжин хот, Шаньси муж, Шааньси муж, Ляонин муж,, Япон улсын Ямагүчи муж ажиллан судлагч статустайгаар оролцож байгаа бөгөөд одоогийн байдлаар Холбооноос зохион байгуулж буй төрөл бүрийн арга хэмжээнд оролцож, мэдээлэл солилцож байна.



Бүтэц, зохион байгуулалт Organization

NEAR Холбоо дараах бүтэцтэй ба төрөл бүрийн харилцаа, хамтын ажиллагааг үр ашигтай явуулахуйцаар зохион байгуулагдсан.



Удирдлага, үйл ажиллагаа

Operation and Activities

1996 онд анхдугаар Бүгд хурлыг зохион байгуулснаас хойш бүгд хурал, ажлын хороо, дэд хороод нь Зүүн хойд Азийн хамтын хөгжил дэвшлийн төлөө идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.

Бүгд хурал нь гишүүн байгууллагуудын даргаас бүрдсэн шийдвэр гаргах дээд байгууллага бөгөөд 2 жил тутамд Холбооны тэргүүлэгч буюу Бүгд хурлын зохион байгуулагчаар томилогдсон гишүүн байгууллагаас Бүгд хурлыг зохион байгуулах ба Холбооны хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, үндсэн дүрмийг шинэчлэх, гишүүн элсүүлэх зэргийг шийдвэрлэнэ.

- Анхдугаар Бүгд хурал(1996. 9 Кёнсанбүг муж)
Орон нутгийн захиргаадын харилцаа бүхий олон улсын байгууллага болохын хувьд үйл ажиллагаагаа албан ёсоор эхлүүлж, 7 зүйлийн нийтлэг зорилтыг гаргасан.
- Хоёрдугаар Бүгд хурал(1998. 10 Тояма муж)
Гишүүнчлэлийн хүрээг өргөтгөх тухай дүрмийг шинэчилж, 5 дэд хороог байгуулсан.
- Гуравдугаар Бүгд хурал(2000. 9 Хёго муж)
Холбооны Хэрэг эрхлэх газрыг байгуулах тухай хэлэлцсэн. БНАСАУ-ын орон нутгийг гишүүнээр элсүүлэх тухай асуудал дээр хамтын хүчин чармайлт гаргахаар тохиролцсон.
- Дөрөвдүгээр Бүгд хурал(2002. 9 Хабаровск хязгаар)
БНАСАУ, Монгол улсыг гишүүнээр элсүүлэхийг зөвшөөрч, Хэрэг эрхлэх газрыг байгуулах хамтарсан ажлын хэсгийг бүрдүүлсэн.
- Тавдугаар Бүгд хурал(2004. 9 Хэйлонжан муж)
БНСУ-ын Кёнсанбүг мужид Хэрэг эрхлэх газрыг байгуулах шийдвэр гарсан.
- Зургадугаар Бүгд хурал(2006. 9 Пусан хот)
Зүүн хойд Азийн хөгжил дэвшил цэцэглэлтэд NEAR Холбооны үүрэг хэмээх хамтарсан мэдэгдэл гаргасан. Шинжлэх ухаан, технологийн дэд хороог байгуулсан.
- Долдугаар Бүгд хурал (2008. 9 Шаньдун муж)
Шаньдун тунхагийг гаргаж, аялал жуулчлал, далай, загасны аж ахуйн дэд хороог шинээр байгуулах шийдвэр гарсан.
- Наймдугаар Бүгд хурал(2010. 10 Кёнгү муж)
Шинээр гишүүн элсүүлэхийг баталсан. Эрдэс баялаг боловсруулалт, зохицуулалт зэрэг 3 дэд хороог шинээр байгуулах шийдвэр гарсан.

Ажлын хороо нь гишүүн байгууллагын тамгын газрын дарга нараас бүрдэх бөгөөд гишүүн байгууллагуудын санал шийдвэрийг зохицуулах, Бүгд хурлаас баталсан тогтоол, харилцаа, хамтын ажиллагааны төсөл зэргийг хэлэлцэн шийдвэрлэнэ.

- Анхдугаар хурал(1997. 8 Кёнсанбүг муж)
Эдийн засаг, худалдаа, соёл урлаг, байгаль орчны салбарын хамтын төсөл явуулах санал дэвшүүлсэн.
- Хоёрдугаар хурал(1999. 7 Тояма муж)
Дэд хороодын үйл ажиллагаа, тайлан, санхүүгийн асуудлыг хэлэлцэж зөвлөлдсөн.
- Гуравдугаар хурал(2001. 8 Хёго муж)
Гишүүний хураамж ногдуулах, Хэрэг эрхлэх газрыг байгуулах тухай хэлэлцсэн.
- Дөрөвдүгээр хурал(2004. 1 Хэйлонжан муж)
Кёнсанбүг мужаас Хэрэг эрхлэх газрыг өөрийн мужид байгуулах хүсэлт тавьсан.
- Тавдугаар хурал(2005. 11 Пусан хот)
Байгууллагын эмблемийг батлах ажлын хэсгийг бүрдүүлэх, гишүүн байгууллагын төрийн албан хаагчийг Хэрэг эрхлэх газарт төлөөлөгчөөр ажиллуулахаар тохиролцсон.
- Зургадугаар хурал(2007. 9 Шаньдун муж)
Холбооны гишүүний хураамжийг нэвтрүүлэх, аялал жуулчлал, далай загасны аж ахуйн дэд хороог шинээр байгуулах санал тавигдсан.
- Долдугаар хурал(2009. 10 Кёнгү муж)
Гишүүний хураамж нэвтрүүлэх тусгай хорооны тохиролцсон зүйлийг тайлагнаж, дэд хороог шинээр байгуулах санал тавигдсан.



Дэд хороод Sub-Committees

Дэд хороод нь бүгд хурал, ажлын хороо болон дэд хороодоос санаачилсан тус тусын төслийг хэрэгжүүлнэ. Хороог зохицуулагч нь тухайн хорооны харилцаа, зохион байгуулалт, удирдлага, үйл ажиллагааг хариуцах бөгөөд гишүүн байгууллагуудын санал дээр үндэслэн сонгогдоно.



Эдийн засаг, худалдааны дэд хороо(Зохицуулагч : Кёнсанбүг муж)

- Гишүүн байгууллагуудын хооронд үр бүтээгч эдийн засаг, худалдааны харилцааг бий болгох, Зүүн хойд Азийн хамтын хөгжил цэцэглэлт, эдийн засгийн тогтвортой хөгжлийг эрэлхийлнэ.
- Жил бүр Зүүн хойд азийн бизнесийг дэмжих хурал болон тухайлсан нэг төрлөөр экспорт, импортийн уулзалт зохион байгуулж, эдийн засаг, худалдааны сүлжээ/цахим худалдааг үүсгэн ажиллуулж байна.



Байгаль орчны дэд хороо(Зохицуулагч : Тояама муж)

- 21-р зууны дэлхийн байгаль орчны асуудлыг шийдэхийн тулд бүс нутгийн орон нутгийн захиргааны байгууллагууд хоорондын хамтын ажиллагааны арга замыг тодорхойлно.
- Далайн эргийн хог хаягдлын судалгаа болон Зүүн хойд Азийн бүс нутгийн нүүдлийн шувууны талаарх хамтарсан судалгаа, өсвөр насныхны ахуй орчны тухай семинар, байгаль орчныг хамгаалах тухай олон улсын семинарийг зохион байгуулж байна.



Боловсрол, соёлын харилцааны дэд хороо(Зохицуулагч : Шиманэ муж)

- Зүүн хойд Азийн орнуудын соёл, амьдралын хэв маягийн тухай харилцан ойлголцлыг бэхжүүлэх үүднээс соёл урлаг, эрдэм шинжилгээний салбар дахь харилцаа, хамтын ажиллагааг явуулж байна.
- Зүүн хойд Азийн орнуудын ардын урлагийн чуулга, хамтлагийг урин тоглуулах, гишүүн байгууллагуудын хүүхэд, залуучуудыг оролцуулан орон бүрийн соёлыг таниулах харилцааны хөтөлбөрийг явуулж байна.



Гамшгаас сэргийлэх дэд хороо(Зохицуулагч : Хёго муж)

- Зүүн хойд Азийн бүсийн гамшгаас сэргийлэх тогтолцоог бодит ажил болгон бэхжүүлэхэд хувь нэмэр оруулж, бүс нутгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхийг эрэлхийлнэ.
- Гамшгаас сэргийлэх салбарын гишүүн байгууллагуудын харилцааг явуулахын тулд жил бүр гамшгаас сэргийлэх талаар сургалт явуулж, гамшгаас сэргийлэх газруудтай танилцуулан мөн гамшгаас сэргийлэх судалгааны үр дүнгийн талаар гишүүн байгууллагуудыг мэдээлгээр хангаж байна.



Хилийн хамтын ажиллагааны дэд хороо(Зохицуулагч : Иркутск муж)

- Хилийн бүсийн эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг өргөжүүлж, аялал жуулчлалын салбарыг идэвхжүүлнэ.
- Хилийн бүс дэх гишүүн байгууллага хоорондын харилцаа, хамтын ажиллагааг идэвхжүүлэхийн тулд хамтын хууль болон хилийн худалдааны хуулийг хамтран батлах, виз олгох ажиллагааг хялбарчлах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийг эрмэлзэнэ.



Шинжлэх ухаан, технологийн дэд хороо(Зохицуулагч : Кёнгин муж)

- Зүүн хойд азийн бүсийн шинжлэх ухаан, технологийн харилцаа, хөгжлийг дэмжинэ.
- 2006 оны есдүгээр сард байгуулагдсан ба цаашид Зүүн хойд азийн бүсийн орон нутгийн захиргааны байгууллагуудын хооронд шинжлэх ухаан, технологийн харилцааг дэмжих зорилгоор үйлдвэрлэлийн үзэсгэлэн худалдаа, шинжлэх ухаан, технологийн мэдээлэл солилцооны хурлыг зохион байгуулахаар төлөвлөөд байна.



Далай, загасны аж ахуйн дэд хороо(Зохицуулагч : Шаньдун муж)

- Зүүн хойд Азийн бүсийн далай, загасны аж ахуйн салбарын харилцаа хамтын ажиллагааг бэхжүүлнэ.
- Шинжлэх ухаан, технологийн форум гэхчлэн эрдэм шинжилгээний хурал зохион байгуулна. Далайн эрэг хавийг хөгжүүлэх, хамгаалах сэдвээр семинар зохиох болон харилцан мэргэжилтэн солилцох зэргээр харилцаа, хамтын ажиллагааг явуулж байна.



Аялал жуулчлалын дэд хороо(Зохицуулагч : Хэнан муж)

- Зүүн хойд Азийн бүсийн гишүүн байгууллагуудын аялал жуулчлалын салбарын хөгжлийг идэвхжүүлэхийн тулд харилцан ашигтайгаар хамтын хөгжлийг эрэлхийлнэ.
- Аялал жуулчлалын зургийн үзэсгэлэн болон сурталчилгааны арга хэмжээ, аялал жуулчлалын хамтын ажиллагааны форум зэргийг зохион байгуулах зэргээр гишүүн байгууллагуудын бодит хамтын ажиллагааны нөхцлийг бүрэлдүүлэхээр төлөвлөөд байна.



Эрдэс баялаг боловсруулалт, зохицуулалтын дэд хороо(Зохицуулагч : Магадан муж)

- Зүүн хойд Азийн бүсийн эрдэс баялаг боловсруулалт, зохицуулалтаар дамжуулан харилцан хөгжлийг эрэлхийлж, эрдэс баялаг боловсруулалт болон цаашдын ажлын талаар технологийн харилцаа явуулах зэргээр төлөвлөж байна.



Эрчим хүч, уур амьсгалын өөрчлөлтийн хороо(Зохицуулагч : Дэгү хот)

- Зүүн хойд Азийн эрчим хүчний технологийн харилцаа ба уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг ногоон хөгжлийн тулд гишүүн байгууллагуудын хооронд төрөл бүрийн харилцаа, хамтын ажиллагааг төлөвлөж байна.



Хүүхэд, эмэгтэйчүүдийн дэд хороо(Зохицуулагч : Дорнод аймаг)

- Зүүн хойд Азийн бүсийн эмэгтэйчүүдийн үүргийг нэмэгдүүлэх ба хүүхэд халамж, эмэгтэйчүүдийн чиглэлээр гишүүн байгууллагууд хооронд төрөл бүрийн харилцаа, хамтын ажиллагаа явуулахаар төлөвлөж байна.

Хэрэг эрхлэх газар & Гишүүнчлэл

Secretariat & Admission

Холбооны Хэрэг эрхлэх газар

- Солонгос улсын Кёнсанбүг мужийн Пухан хотод 2005 оны 5 сарын 2-ны өдөр байгуулагдсан.
- Бүтцийн хувьд 1 газар, 2 хэлтэстэй ба ерөнхий нарийн бичгийн дарга, даргын орлогч, бодлого төлөвлөлтийн хэлтэс, олон улс, хамтын ажиллагааны хэлтсээс бүрдэх бөгөөд Кёнсанбүг мужийн төрийн албан хаагч, гишүүн байгууллагуудыг хариуцсан мэргэжилтэн, гишүүн байгууллагуудын төлөөлөгч ажиллаж байна.
- Хэрэг эрхлэх газрын үүрэг нь төсөв тооцох, зарцуулах, санхүүгийн тайлан боловсруулах, гишүүн байгууллагуудтай ажлын уялдаа харилцаатай байх, түүнчлэн гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх болно.

Гишүүнчлэл

• Гишүүнчлэл

- Гишүүнчлэлд хамрагдах этгээд нь Зүүн хойд Азийн бүсэд байрлах ба тус Холбооны зорилгыг дагах орон нутгийн захиргааны байгууллага байна.

• Элсэх явцын тухайд

- Тус Холбоонд гишүүнээр элсэхийг хүсч буй орон нутгийн захиргааны байгууллага нь Хэрэг эрхлэх газарт хүсэлтээ гаргаж, бүгд хурлаар батлуулах ёстой.



The Association of North East Asia
Regional Governments

The Association of North East Asia Regional Governments

БНСУ, Кёнсанбүг муж, Пухан хот, Намгү Жигүгдун 601, Шуудангийн хайрцаг 790-834
TEL +82-54-223-2311~2320/ FAX +82-54-223-2309
Website : www.neargov.org